



АТАР-ӨРГӨӨ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 03 сарын 11 өдөр

№ 20/04

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.3, 60.4, 67 дугаар зүйлийн 67.1, Компанийн дүрмийн 7.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоол, Төлөөлөн удирдах Зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Атар-Өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 10:00 цагаас компанийн байр (Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-20, Атар-Өргөө ХК-ийн байрны хурлын танхим)-д хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:
 - Компанийн 2019 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
 - Компанийн 2019 оны жилийн санхүүгийн тайланд ээлжит аудит хийсэн аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах.
 - Ногдол аниг хуваарилсан тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах.
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийг батлах.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын даргад:	Б.Мөнхдалай	ТУЗ-ийн дарга
Гишүүдэд	Ц.Доржготов	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
	И.Артём	Гүйцэтгэх захирлын туслалцаа
4. Хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст даалгах нь:
 - Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зар мэдээг 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл (өдөр тутмын сонин, телевиз) болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудас, бусад мэдээллийн хэрэгсэлээр хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх.
 - Энэхүү мэдээллийг 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэх.
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай мэдэгдлийг холбогдох бичиг баримтын хамт Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад 2020 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн дотор хүргүүлэх.
 - Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, тэдгээрийн танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төсөл, санал авах хуудсыг үнэт цаасны брокер, диллерийн

компанид хэвлэмэл болон цахим хэлбэрээр 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн дотор хүргүүлэх.

- Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл болон хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийг 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс мөн оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 10-13, 14-17 цагт компанийн байранд хувьцаа эзэмшигчдэд танилцуулж, саналын хуудсаар санал авах.
- 5 Хурал зарласан хугацаанд хувьцаа эзэмшигчдэд дор дурдсан баримт бичгийг танилцуулахыг хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст зөвшөөрсүгэй. Үүнд:
- Компанийн 2019 оны жилийн санхүүгийн тайлан.
 - Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудиторын дүгнэлт.
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн тухай танилцуулга.
 - Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин, урамшуулал.
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд холбогдох бусад мэдээлэл.
 - Хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад мэдээлэл.
- 6 Ээлжит хурлын “Санал авах хуудас”-ны загварыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
- 7 Ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөр тогтоосугай.
- 8 Хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн санал авах хуудсыг хүлээж авах сүүлчийн хугацааг 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 17.00 цагаар тогтоосугай.
- 9 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Мөнхдалайг сонгосугай.
- 10 Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооны 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 01 дугаар шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын даргаар Ч.Жадамба, гишүүнээр Э.Түвшинбаяр, Ц.Энхтүвшин нарыг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН
ХУРЛЫН ДА



Б.МӨНХДАЛАЙ



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН

Компанийн оноосон нэр: "Атар-Оргоо" ХК

Хурал хуралдах газар, өдөр: "Атар-Оргоо" ХК-ийн хурлын танхимд
2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр 10:00 цагт

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр	
Регистрийн дугаар	
Хувьцаа эзэмшигчийн утасны дугаар	
Итгэмжлэл эр оролцож байгаа бол итгэмжлэгдсэн этгээдийн нэр	
Эзэмшиж буй хувьцааны тоо	
Харилцагчийн дугаар	
БДК-ийн нэр	

№	Хэлэлцэх асуудал	Хувьцаа эзэмшигчийн санал		
		Зөвшөөрсөн	Татгалзан	Гүдгэлзсэн

№	Нэр дэвшигчид	Кумулятив аргаар өгсөн санаах тоо
	Ердийн гишүүн	
	Хараат бус гишүүн	

Хувьцаа эзэмшигчийн Нэр Гарын үсэг	Хувьцаа эзэмшигчийн хуулийн этгээдийг тооцож хурал оролцсон итгэмжлэгдсэн тооологчийн Нэр Гарын үсэг
--	---

Саналыг хуудсыг хүчинтэйд тооцож тоолсон:

Тоологын комиссын дарга
Гиншүүд

Хүчинтэйд тоолсон бол шалтгаан:

.....
.....
.....